

ТӨРИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН МАНЛАЙЛАЛ

Д.Алтанжолоо

Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах,
олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн монгол банкны
гэрээт харуулын цагдаа,

Оршил:

Төрийн тусгай байгууллагын манлайлал нь байгууллагын алсын хараа, хүмүүсийг идэвхжүүлэхэд, байгууллагын хүрээлэн буй орчинд гарч буй өөрчлөлтөд дасан зохицох, өөрчлөлт хийхэд тусалж байдаг. Төрийн албаны удирдах албан тушаалтныг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулж тухайн албан тушаалд томилох нь төрийн албаны удирдах ажилтны үр нөлөөтэй манлайллыг хангахад түлхэц үзүүлдэг. Төрийн албаны удирдах ажилтнуудын хувьд тэдний манлайлах болон баг бүрдүүлэх, байгууллагынхаа гадаад, дотоод орчны хүрээнд үр бүтээлтэй ажлын харилцааг бий болгох, бусадтай үр нөлөө бүхий ажлын харилцаа тогтоох, өөрийн биеэр үлгэрлэн, өөрийгөө дайчлан шударгаар ажиллах, үр дүнд хүрэх зэрэг ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай юм. Удирдах албан тушаалтан гэлтгүй бүх түвшний алба хаагчид өөрийн манлайлах ур чадварыг хөгжүүлснээр төрийн үйлчилгээг сайжруулж иргэдийн хэрэгцээг хангах, байнгын өөрчлөгдөн хувьсаж буй нөхцөл байдалд уян хатан ханддаг, идэвхтэй, үр дүнд чиглэсэн орчин цагийн манлайллыг төрийн албанд төлөвшүүлэх шаардлагатай байна.

Үндсэн хэсэг

Төрийн албаны манлайллыг ярихын өмнө юун түрүүнд манлайлал гэдэг юу болохыг ойлгох хэрэгтэй. Манлайллыг хүмүүс олон янз бүрээр тодорхойлсон байдаг. Манлайлал нь нийтийн үйл хэргийг биелүүлэхэд хэн нэгэн хүн бусдадаа сайн дураар тусламж дэмжлэг үзүүлэх нийгмийн нөлөөний үйл явц гэж тодорхойлж болно./Wikipedia, Encyclopedia/. Манлайлал гэдэг нь итгэл үнэмшил, үнэт зүйлс, ёс зүй, зан чанар, мэдлэг, чадвараараа удирдан манлайлж бусдыг зорьсондоо хүрэхэд нөлөөлөх процесс юм. /Европын эрдэмтэд/. Хамгийн агуу манлайлагч бол өөрийн мөрөөдөлдөө бусдыг итгүүлж чаддаг хүн юм /Ли Куан И, Сингапурын Ерөнхий сайд асан/ гэх зэргээр хүмүүс манлайллыг тодорхойлсон байдаг¹. Манлайлагч хүн хүмүүсийн үнэт зүйлс, зан төлөв болон хандлагад нөлөөлж өөрчлөлт шинэчлэлийг удирдан зааварлаж нэг ойлголтод хүргэх ур чадваруудын нэгдэл бөгөөд байгууллагын бүх түвшинд байвал илүү үр дүнтэй. Гэхдээ байгууллагад манлайлагч гэсэн тусдаа албан тушаал байдаггүй. Үзэл баримтлал, зорилгоо тууштай хамгаалж, ёс зүй, шударга зан чанар, мэдлэг чадвар, туршлага, хариуцлага, үйл хөдлөлөөрөө бусдад үлгэр дуурайлал болж

¹ <https://academy.edu.mn>

байдаг. Бүгдийг бодож төлөвлөсний дагуу хийж, хүмүүст хүрэх зорилго, түүнийг хэрэгжүүлэх арга замыг зааж өгөх, тусалж дэмжих, хүмүүстээ ач холбогдол өгч, адил боломж олгон, тэднийг үзэл бодол санаагаа илэрхийлэхийг хүлээн зөвшөөрч, хийж бүтээх боломж нөхцөлийг нь бүрдүүлж өгөх шаардлагатай. Харилцан итгэлцлийн уур амьсгалыг бүрдүүлж хамт олноо нэг зорилго, нэг санаатай болгож багийн ажиллагааг хөгжүүлж, чөлөөт сэтгэлгээтэй, шинэлэг арга барилаар ажиллаж, байгууллагаа шинэчлэлд бэлтгэн, шинэчлэлийг хэрэгжүүлж эерэг өөрчлөлтийг авчрах ажилдаа бүгдийг зориулснаар манлайлал бий болдог. Алба хаагчдын ажлын идэвх манлайлал буурах нэг шалтгаануудын нэг нь бухимдал (стресс), холбогдох шалтгаанууд нь ажлын ачаалал их, цалин бага, төлөвлөгдөөгүй гэнэтийн ажилд байнга дайчлагддаг, гэр орны ахуй нөхцөл хүнд, гэх мэтээр алба хаагчид өөрсдөө илэрхийлж байсныг сургалтын хөтөлбөр боловсруулах хүрээнд цагдаагийн алба хаагчидтай “нэр хаяггүй” уулзалт, ярилцлага хийж асуудлын шалтгааныг тодруулсан байдаг¹.

Манлайлагчийн харилцааны ур чадварыг эзэмшихийн тулд дараах чадваруудад тууштай суралцах хэрэгтэй байдаг. Үүнд:

Өөрийгөө таних – Өөрийн зорилготой, шударга, нээлттэй, шүүмжлэлийг хүлээж авдаг, давуу ба сул тал болон бусдад ямар нөлөө үзүүлж чадахаа мэддэг, үнэт зүйлстэй байх зэрэг суурь ур чадварууд бөгөөд “Хандлагыг” тодорхойлдог.

Өөрийгөө хянах – Зан авир, сэтгэл хөдлөлөө удирдаж зөрчлийг багасган шударга, хариуцлагатай орчинг бий болгож “Өөрчлөлтийг” хурдан хүлээж авах чадвар.

Өөрийгөө сэдэлжүүлэх – Хүрсэн амжилтаараа өөртөө урам зориг өгдөг, эрч хүчтэй, ажилдаа дуртай, байнга суралцах, шинэлэг арга барил эзэмших чадвар.

Бусдыг ойлгох – Бусдыг сонсох, тэдний сэтгэл хөдлөлийн сэдэл хэрэгцээг нь ойлгож, чадварлаг ажилтнуудаа алдахгүй байх чадвар.

Нийгмийн харилцааны ур чадвар – Танилын хүрээ өргөн, бусадтай тааламжтай харилцаа тогтоон, тэднийг чиглүүлж өөрийн зорилгод итгүүлж чаддаг байх чадвар.

Эдгээр ур чадварууд нь төрийн тусгай байгууллагын удирдлага, алба хаагч нарт хэрэгтэй төдийгүй жирийн ажилтнуудад ч амжилттай ажиллахад хэрэгтэй. байдаг².

Ажилтан алба хаагчдынхаа манлайлах, удирдах чадамжид олон талаас нь харсан бодит үнэлгээг өгөх, чадамжийн түвшинг тодорхойлох, манлайллыг хөгжүүлэхдээ ажлын байран дээр сургах, сургалт, семинарт

¹ Жаргалсайхан. Д, Туяа. У., “Цагдаагийн алба хаагийн ёс зүйн харилцаа” 8 дахь тал. УБ 2014 он.

² <https://business.mn/2020/03/23/manlaillyn-tuhai-oilgolt/>

оролцуулах, туршлагатай ажилтнаас суралцах, хамтран ажиллах, сэлгэн ажиллах, өөрийгөө хөгжүүлэх хөтөлбөрүүд, дотоод сургалт, хөтөлбөрт хамрагдах зэргээр алба хаагчдын манлайллыг сайжруулах боломжтой. Манлайллыг зөвхөн заяамал шинжтэй, цөөн тооны шилмэл хүмүүст л хамаатуулж ойлгодог байсан ойлголт орчин үед эрс өөрчлөгдөж бизнесийн ертөнц илүү өрсөлдөөнтэй, улам тогтворгүй болж буйтай холбогдон манлайлагчдын хэрэгцээ улам бүр өссөөр байна. Манлайллын ур чадварт суралцах, эзэмших нь хүн бүрд нээлттэй, боломжтой бөгөөд гагцхүү өөрийн зорилгодоо тууштай, суралцагч, шинийг эрэлхийлэгч, зөв хандлагатай байвал жинхэнэ манлайлагч болж чадах нь нотлогдсон.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллага нь тусгай чиг үүргийнхээ хүрээнд төрийн байгууллагуудын нүүр царай, иргэдтэй холбох гүүр, индэрт гарах шат болж ард иргэдэд төрийн түргэн, шуурхай үйлчилгээг хүргэдэг билээ. Төрийн тусгай байгууллагын алба хаагчид хууль, дүрэм, журам, шийдвэрийг ёсчлон биелүүлж албандаа итгэл үнэмшилтэй ажилдаа хариуцлагатай, идэвх зүтгэлтэй байж галаар бол иргэдэд өгөх оч болж өгдөг. Ард иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд төрийн бусад чиг үүргийн байгууллагуудыг манлайлж ажиллах шаардлага гардаг. Төрийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахын тулд хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг зөв зүйтэй зохион байгуулж, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, ажлын байранд шаардагдах тоног төхөөрөмж, хэрэглээний багаж хэрэгслээр бүрэн хангаж, алба хаагчдын сэтгэл зүйг бэлдэж ажиллах орчинд нь хурдан дасгах, дадлагажуулах арга хэмжээг авахын тулд ажлын байранд дасан зохицох төлөвлөгөө боловсруулан сар, улирал бүрээр үр дүнг тооцож алба хаагчдын хийсэн ажлыг үнэлж, дүгнэн алдаа, дутагдал гарсан тохиолдолд засах, сайжруулах шаардлагатай зүйлсийг тухай бүр зөвлөж, шаардлагатай арга хэмжээг авч алба хаагчдыг өдөр тутам хөгжүүлж манлайллыг дээшлүүлж байна. Зөвхөн дарга удирдлага манлайлдаг гэсэн хайрцаглагдсан сэтгэхүйг өөрчилж алба хаагч бүрийг хөгжүүлснээр төрийн тусгай байгууллагын манлайлал нэмэгдэж, цаашлаад төрийн үйл ажиллагаа сайжрах боломжтой.

Ном зүй

1. Жаргалсайхан. Д, Туяа. У., “Цагдаагийн алба хаагийн ёс зүйн харилцаа”. УБ 2014 он.
2. <https://academy.edu.mn>
3. <https://business.mn/2020/03/23/manlaillyn-tuhai-oilgolt/>